

**ЭРЭЭНЦАВ-БАЯНТҮМЭНИЙ ТӨМӨР ЗАМЫН
ГЭРЭЭ БИЧИГ
(1941)**

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар ба Зөвлөлт Засагт Нийгэм Журамт Холбоот Улсын Засгийн газар нь Зөвлөлт Засагт Нийгэм Журамт Холбоот Улсын хүчээр ба хөрөнгөөр Бүгд Найрамдах Монгол Ард Улсын дэвсгэр нутаг дээр. Эрээнцав, Баянтүмэн хэмээх хоёр газрын хооронд үүний урьд хэлэлцэн тогтсоны ёсоор байгуулсан төмөр замыг ашиглах ба захирах журмыг тогтоохын тулд дор дурьдсанаар хэлэлцэн тогтсон үүнд:

Нэгдүгээр зүйл.

248 километр одоогийн хэмжээ бүхий цаашид товчлон төмөр зам хэмээн нэрийдэх Эрээнцав, Баянтүмэн хоёрын хоорондох төмөр зам хийгээд төмөр замыг ашиглах явдалд хэрэглэгдэх тосгон буудлуудын барилга засварын газрууд, агуулах газар, суух орон байшин, телефон ба телеграмм утасны шугам, радиогийн станц зэргийн барилгууд нь энэхүү гэрээ бичиг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 66 жилийн дотор Зөвлөлт Засагт Нийгэм Журамт Холбоот Улсын Засгийн газрын өмч болох бөгөөд энэхүү төмөр зам нь түүнээс томилогдсон захиргаагаар захирагдаж байна. Зөвлөлт Засагт Нийгэм Журамт Холбоот Улсын Засгийн газар нь төмөр замыг хийгээд туслан үйлдвэрлэх газруудыг захиран удирдаж ашиглахын тулд өөрийн үзэмжээр зохих албан байгууллагыг хуулийн эрх бүхийтэйгээр байгуулж болно.

Хоёрдугаар зүйл.

Төмөр замын бүх дагуу газрын өргөнөөр нэг зуун метр (замын хоёр талд тавь тавин метр) мөн Эрээнцав, Баянтүмэн хийгээд тэрхүү хоёр буудлын хоорондоо дамжлага тосгон буудлуудын газар буудал тутам уртаар нэг мянга хоёр зуун метр, өргөнөөр хоёр зуун метр дэвсгэр газар тус тусыг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газраас энэхүү гэрээ бичигт хавсаргасан төлөвлөгөөний ёсоор төмөр замыг ашиглах явдалд хэрэглэгдэх барилгуудыг бариулахаар олгосон нь энэхүү гэрээ бичгийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 66 жилийн дотор ямар ч үнэ төлбөргүй. Зөвлөлт Засагт Нийгэм Журамт Холбоот Улсын Засгийн газрын эдлэлгээнд байна. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар нь цаашид

төмөр замын захиргаа, түүний захиалгын ёсоор элс чулуу, шохой зэргийн бусад материалыг авахад хэрэглэгдэх газрыг саадгүй ба үнэ төлбөргүйгээр даруй олгон өгч байхыг зөвшөөрнө.

Гуравдугаар зүйл.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар нь төмөр замыг захиран удирдах, ашиглах, засварлах, өөрчлөн байгуулах хийгээд элдэв төрлийн харилцааг хэрэглэх, мөн түүнчлэн төмөр замын ажилчид, албан хаагчдыг тархаан суулгах, ийш тийшээ шилжин явах зэрэг төмөр замын захиргааны ажилд үл оролцох ба саадыг үл учруулах болно.

Дөрөвдүгээр зүйл.

Зөвлөлт Засагт Нийгэм Журамт Холбоот Улсын Засгийн газар нь энэхүү гэрээ бичгийн хоёрдугаар зүйлд дурьдсан дэвсгэр газраа төмөр зам түүний орон сууц, барилга замыг сахиж хамгаалах ба явах явдлыг аюулгүй байлгах явдлыг хангаж чадах хэмжээний зэвсэг бүхий манааг байлгах эрхтэй болно.

Тавдугаар зүйл.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын дэвсгэр нутаг дээр оруулан ирүүлэх төмөр замын буудлууд, хүрэлцэн ирэх замууд, карьер хийгээд орон байшин барилгуудыг ашиглах ба засварлах, харж хамгаалах ба бариулах явдалд хэрэглэгдэх, мөн түүнчлэн төмөр замд хэрэглэгдэх хөдлөх зүйлүүд нь Бүгд Найрамдах Монгол Ард Улсын дэвсгэр нутаг дээр одоо дагаж явуулагдаж буй ба мөн үүнээс хойшид ч явуулагдаж болох гаалийн ба өөр бусад татваруудаас чөлөөлөгдөх болно.

Зургадугаар зүйл.

Үүний урьд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын дэвсгэр нутаг дээр төмөр замыг байгуулахаар ба ашиглах, засварлах, хамгаалахаар оруулж ирүүлсэн бөгөөд өөр эд хогшил хөдлөх зүйлээр солихын тулд Зөвлөлт Засагт Нийгэм Журамт Холбоот Улсад буцаахад ямар ч саадыг үзүүлэхгүй явдлыг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар нь зөвшөөрнө хэмээхийн гадна энэ мэтийн зүйлүүд нь Бүгд Найрамдах Монгол Ард Улсын дэвсгэр нутгаас гадагш авахад Бүгд Найрамдах Монгол Ард Улсын дэвсгэр нутаг дээр дагаж явуулагдаж буй ба үүнээс хойш ч явуулагдаж болох гааль, албан татвар зэргийн аливаа нэгэн татваруудаас чөлөөлөгдөх болно.

Долдугаар зүйл.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар нь төмөр замаар тээвэрлэн буй ачааг, гаалийн бүрэлдэхүүнийг төмөр замын хуваарилт төлөвлөгөөгөөр тэгшитгэгдэн буй төмөр замын харилцааны хэвийн байдлыг алдагдуулах ба саатуулахгүйгээр хөнгөн журмаар гүйцэтгэх бололцоог буй болгон өгөхийг зөвшөөрнө.

Наймдугаар зүйл.

Төмөр замаар ачаа бараа, суудлын хүмүүсийн ба тэд нарын гарын ачааг тээвэрлэсний хөлсийг энэхүү гэрээ бичгийн хүчинтэй байх цагт СССР-ийн Зам харилцааны Ардын комиссариатын газраас тогтоон гаргасан тариф ба журмаар нэхвэрлэгдэн авагдах бөгөөд төмөр замыг ашигласан явдлаас орсон мөнгийг Зөвлөлт Засагт Холбоот Улсын Засгийн газраас Бүгд Найрамдах Монгол Ард Улсын дэвсгэр нутаг дээр ба чөлөөтэй гуйвууллагын журмаар түүний гадна ямар нэгэн төлбөрт ба зардалд хэрэглэж болно.

Есдүгээр зүйл.

Төмөр замын орлогууд ба түүнээр тээвэрлэн буй ачаа суудлын хүмүүс тэд нарын гарын ачааны тээвэрүүд, мөн түүнчлэн төмөр замын эдлэлгээнд буй газар дэвсгэр, аливаа нэгэн эд хогшилууд нь Бүгд Найрамдах Монгол Ард Улсын дэвсгэр нутаг дээр дагаж явуулагдан буй ба үүнээс хойшид ч явуулагдаж болох аливаа нэгэн татваруудаас чөлөөлөгдөнө.

Аравдугаар зүйл.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар нь Зөвлөлт Засагт Холбоот Улсаас урьд ирүүлэх төмөр замын инженер техникийн ба ажилчдыг Бүгд Найрамдах Монгол Ард Улсад чөлөөтэй нэвтрэн ирэх явдалд саадгүй зөвшөөрлийг олгож байна.

Арван нэгдүгээр зүйл.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын ард иргэдийн дотроос төмөр замын боловсон хүчнийг бэлтгэх явдалд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт тусламжийг үзүүлэхийн үүднээс үүнд зориулан зохих курс сургуулиудыг байгуулах явдлыг Зөвлөлт Засагт Нийгэм Журамт Холбоот Улсын Зам харилцааны Ардын комиссариатын газраа даалгана.

Арван хоёрдугаар зүйл.

Төмөр замыг байгуулах ба ашиглах талаар холбогдсон өдөр тутмын асуудлуудыг хэлэлцэн тасалж байх явдлыг Зөвлөлт улсын тал болж буй Төмөр замын дарга, мөн Монгол улсын тал болж буй Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Тээврийн яамны төлөөлөгчөөс тус тус харилцан уул газар дээр нь таслан шийдвэрлэж байна.

Арван гуравдугаар зүйл.

Энэхүү гэрээ бичгийн нэгдүгээр зүйлд заасан 66 жилийн хугацаа өнгөрсний дараа төмөр зам нь туслах чанарын бүхий л байшин барилгуудын хамт үнэ төлбөргүйгээр Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газрын өмч болж шилжинэ. Дээр заасан хугацаа дуусахын урьд нэг жилийн өмнө хоёр тал нь төмөр замыг хүлээн авах ба шилжүүлэн өгөх хавсарсан тэгш комиссыг томилно. Энэхүү хавсарсан тэгш комисс нь нэг жилийн дотор төмөр замыг түүний жинхэнэ байдлаар хүлээн авах ба шилжүүлэн тушаах ажлыг гүйцэтгэж, энэ тухай хүлээн авсан ба шилжүүлэн тушаасан тухайн акт бичгийг үйлдэн гаргана.

Арван дөрөвдүгээр зүйл.

Энэхүү гэрээ бичгийн 13 дугаар зүйлд дурьдсан төмөр зам хийгээд, түүний туслах чанарын байшин барилгуудыг шилжүүлэн тушаахын нэгэн хамт Зөвлөлт Засагт Нийгэм Журамт Холбоот Улсын Засгийн газар нь шилжүүлэх үест төмөр замын мэдэлд байгаа бөгөөд цаашид төмөр замыг ашиглах явдалд хэрэглэгдэх паровоз, вагон, дрезин мэтийн хөдлөх зүйлүүд ба багаж хэрэглэл, эд хогшил, материалыг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газраа тэд нарын үнийг хоёр талын харилцан тогтоосон тусгай хэлэлцээний ёсоор тогтоогдсон хэмжээгээр Зөвлөлт Засагт Нийгэм Журамт Холбоот Улсын Засгийн газарт төлөхөөр шилжүүлнэ.

Арван тавдугаар зүйл.

Төмөр замыг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газрын өмч болж шилжсэний дараа тэрхүү төмөр замыг хэнд ч бууж өгөхгүй ба шилжүүлэн өгөхгүй, мөн түүнчлэн төмөр замыг дэнчин болгож бариулахгүй явдлыг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар нь үүрэг болгон биедээ хүлээнэ.

Арван зургаадугаар зүйл.

Энэхүү төмөр зам нь Зөвлөлт Засагт Нийгэм Журамт Холбоот

Архивын сан хөмрөгөөс

Улсын өмч байхдаа ба мөн цаашид Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газрын өмч болохдоо Зөвлөлт Засагт Нийгэм Журамт Холбоот Улсын төмөр замтай холбогдох бөгөөд СССР-ийн замын салаатай байваас зохино.

Арван долдугаар зүйл.

Энэхүү гэрээ бичиг нь 66 жилийн хугацаанаа байгуулагдав. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газрын хүсэлтийн ёсоор харилцан тогтож буй хоёр талаас тусгай хэлэлцээг байгуулж, уг төмөр замыг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газрын өмч болгон шилжүүлэх явдлыг хойшлуулж болно. Үүнд, хэрэв шилжүүлэх явдлыг хойшлуулсан байх аваас уул гэрээ бичиг нь төмөр замыг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар шилжүүлэх цаг хүртэл хүчин төгөлдөр үргэлжлэн явна.

Арван наймдугаар зүйл.

Энэхүү гэрээ бичиг нь түүнд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж улмаар дээд газраа батлуулах явдлыг үл хэрэглэнэ.

Арван есдүгээр зүйл.

Энэхүү гэрээ бичиг нь орос, монгол хэл дээр тус тус хоёр хувь үйлдсэн болох бөгөөд тус тус нь нэгэн адил хүчин төгөлдөр болно.

1941 оны 8 дугаар сарын 23-ны өдөр. Улаанбаатар хотноо үйлдэн тогтоов.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ТӨЛӨӨЛӨЛӨӨР
БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
АРДЫН САЙД НАРЫН ЗӨВЛӨЛИЙН
ЕРӨНХИЙ САЙДЫН ГУРАВДУГААР ОРЛОГЧ САЙД

/ЛАМЖАВ/

ЗӨВЛӨЛТ ЗАСАГТ НИЙГЭМ ЖУРАМТ ХОЛБООТ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ТӨЛӨӨЛӨЛӨӨР
СССР УЛСААС БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСАД СУУГАА
ХУДАЛДААНЫ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ОРЛОГЧ

/ТРУСОВ/

